



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2013 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/921

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Засгийн газрын эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.10, 25.2 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Уснаас эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах журам"-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү журмыг мөрдөж ажиллахыг Аврах тусгай анги, аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтсийн дарга, захирагч нарт үүрэг болгосугай.
3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга (онцгой байдлын хурандаа Д.Дарь Сүхбаатар)-д даалгасугай.

3

ДАРГА,  
ОНЦГОЙ БАЙДЛЫН ХУРАНДАА



Т.ДУЛАМДОРЖ

## УСНААС ЭРЭН ХАЙХ, АВРАХ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Үер, усны аюулаас эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулахад энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.2. Журам нь онцгой байдлын ерөнхий газрын харъяа Аврах тусгай анги болон аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтсийн аврах анги, салбаруудын уснаас эрэн хайх, аврах ажиллагаанд оролцох албан хаагчдад хамаарна.

Хоёр. Нэр, томъёоны тодорхойлолт

*2.1. Мэргэжлийн нэр томъёо:*

2.1.1. “Аврах ажиллагааны даалгавар” гэж аврах ажиллагааны гүйцэтгэлийн баримт бичгийг;

2.1.2. “Анги, салбарын захирагч (аврах ажиллагааны ахлах удирдагч)” гэж анги, салбарыг удирдах эрх бүхий мэргэшсэн албан хаагчийг;

2.1.3. “Аврах бүлгийн дарга (аврах ажиллагааны удирдагч)” гэж үүссэн цагийн байдлыг үнэлж дүгнэх, эрэн хайх, аврах, учирсан хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг шуурхай удирдлага, зохицуулалтаар хангах эрх бүхий мэргэшсэн албан хаагчийг;

2.1.4. “Аврагч-усчин” гэж уснаас эрэн хайх, аврах ажиллагааг гүйцэтгэх мэдлэг, дадлага бүхий бэлтгэгдсэн албан хаагчийг;

2.1.5. “Ажиллаж буй шумбагч” гэж шумбалтын ажиллагааны даалгаврыг гүйцэтгэж буй аврагчийг;

2.1.6. “Аврагч-жолооч, холбоочин” гэж аврах бүлгийг шаардлагатай газар, оронд шуурхай хүргэх, анги, салбартай холбоогоор хангах албан хаагчийг;

2.1.7. “Буцалтгүй нэрвэгдэгч” гэж амьд биш нэрвэгдэгч буюу (хүний цогцос)-ыг;

2.1.8. “Туслах-аврагч (шумбагч)” гэж ажиллаж буй шумбагчийг үүрэг гүйцэтгэхэд туслах шумбагчийг;

2.1.9. “Уснаас эрэн хайх, аврах бүлэг” гэж тусгай зориулалтын автомашин, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас хэрэгслээр тоноглогдсон шумбагч болон аврагч-усчин нарын 6-аас доошгүй хүнтэй бүрэлдэхүүнийг;

2.1.10. “Уснаас эрэн хайх, аврах үндсэн бүлэг” гэж анги, салбарын тухайн өдрийн томилгоот бүрэлдэхүүнийг;

2.1.11. “Уснаас эрэн хайх, аврах бэлтгэл бүлэг” гэж нэмэлтээр ажиллах томилгоот бүрэлдэхүүнийг;

2.1.12. “Уснаас эрэн хайх, аврах нэмэлт бүлэг” гэж нэмэлтээр ажиллах дуудагдах томилгоот бүрэлдэхүүнийг;

2.1.13. “Уснаас эрэн хайх, аврах нөөц бүлэг” гэж амарч байгаа бүрэлдэхүүнийг;

2.1.14. “Хамгаалагч-аврагч (шумбагч)” гэж ажиллаж буй шумбагчид тусламж үзүүлэх шумбагчийг;

2.1.15. “Шумбагчийн мэргэжил” гэж усны шумбалтын хэрэгсэлтэйгээр усны гүнд эрэн хайх, аврах цогц үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр зохион байгуулж хэрэгжүүлэхэд шаардагдах мэдлэг, чадвар, дадлыг;

2.1.16. “Шумбагч” гэж тусгайлан усны гүний шумбалтын ажиллагаанд бэлтгэгдэж мэргэшсэн эрх бүхий албан хаагчийг;

2.1.17. “Шумбалтын бүртгэл” гэж шумбалтын бүртгэлийн ажиллагааны баримт бичгийг;

2.1.18. “Шумбагчийн хувийн дэвтэр” гэж шумбагчийн бүх үйл ажиллагааг харуулсан баримт бичгийг;

2.1.19. “Шумбагчийн эрүүл мэндийн үзлэгийн хуудас” гэж шумбагчийн эрүүл мэндийн байдлыг тогтоох зорилгоор усны гүнд орохоос өмнө, усны гүнээс гарсны дараах эмчийн дүгнэлтийг;

2.1.20. “Шумбагчийн хувийн эрүүл мэндийн дэвтэр” гэж шумбагчийн эрүүл мэндийн байдлыг тогтоох зорилгоор усны гүнд орохоос өмнө болон усны гүнээс гарсны дараах үеийн эмнэлгийн цогц үзлэгийг харуулсан баримт бичгийг;

2.1.21. “Эмч-аврагч” гэж аврагчдын эрүүл мэндэд хяналт тавих, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх эмнэлгийн ажилтан зааварлагчийг;

## *2.2. Ажиллагааны нэр томьёо:*

2.2.1. “Аврагчийн дохио” гэж аврах ажиллагааны үеийн аврагч нарын хоорондын харилцааг илэрхийлэх хөдөлгөөнийг;

2.2.2. “Аврах ажиллагааны шумбалт” гэж усны гүнд даалгавар гүйцэтгэх зорилгоор усанд шумбахыг;

2.2.3. “Гүний өвчин” (кессоны өвчин) гэж усны гүнд ажиллаж байх үед хүний биед үүссэн даралт нэмэгдэх, хасагдахаас үүссэн өвчнийг;

2.2.4. “Дадлагын шумбалт” гэж мэргэшлээ батлах, бие махбодоо дасгах, дасгал гүйцэтгэхийг;

2.2.5. “Даралтад оруулах” гэж шумбагчийг усны гүний шумбалтын хэрэгсэлтэй оруулах, барокамерт даралтыг нэмэх үйл явцыг;

2.2.6. “Даралтаас гаргах” гэж шумбагчийг барокамерт эсвэл усны гүнээс гаргахад бие махбодод шаардлагатай азот, гелий, аргон ба бусад хийг нэмэгдүүлэхийн тулд даралтыг багасгах үйл явцыг;

2.2.7. “Мөс цөмөрсөн үеийн эрэн хайх, аврах ажиллагаа” гэж мөсөн доор усны гүнд үүрэг гүйцэтгэхийг;

2.2.8. “Мэргэшлийн шумбалт” гэж үндсэн мэргэжлээ батлах болон нэмэлт мэргэшилд шаардлагатай даалгавар гүйцэтгэхийг;

2.2.9. “Сургалтын шумбалт” гэж сургалтын хөтөлбөрийн дагуу шумбалтын мэргэжил эзэмшихээр бэлтгэл хийх шумбалтыг;

2.2.10. “Туршилтын шумбалт” гэж шинэ төрлийн техник, тусгай зориулалтын усны гүний шумбалтын хувцас хэрэглэл, тоног төхөөрөмжийг туршихийг;

2.2.11. “Усны гүнд шумбах ажиллагаа” гэж усны гүн рүү аврах ажиллагаа, сургалт, дадлага, мэргэшлийн, туршилтын зорилгоор хамгаалах хувцас, тоног төхөөрөмжтэй усанд шумбахыг;

2.2.12. “Урсгал уснаас эрэн хайх, аврах ажиллагаа” гэж урсгал усанд урсаж осолдсон хүн, мал, амьтан, эд хөрөнгийг аврах ажиллагааг;

2.2.13. “Усны гүнээс эрэн хайх, аврах ажиллагаа” гэж урсгалгүй тогтмол усан орчинд живсэн хүн, мал амьтан, эд хөрөнгийг гаргах ажиллагааг;

2.2.14. “Усны бага гүн” гэж 12 метр хүртэл усны гүн;

2.2.15. “Усны дунд гүн” гэж 12 метрээс дээш 25 метр хүртэл усны гүн;

2.2.16. “Усны их гүн” гэж 25 метрээс дээш усны гүн;

2.2.17. “Усанд осолдох” гэж хүн болон мал амьтан, эд зүйлс, тээврийн хэрэгсэл, барилга байгууламж усанд автах, урсах, живэхийг;

2.2.18. “Үзэгдэх орчин хязгаарлагдмал үеийн аврах ажиллагаа” гэж цасан болон шороон шуурга, аянга цахилгаантай ширүүн бороо, манан будан, түймрийн утаа, ой, шөнийн цагт үүрэг гүйцэтгэхийг;

2.2.19. “Хүнд механизм ашиглаж аврах ажиллагаа явуулах” гэж усанд осолдсон тээврийн хэрэгслийг татан гаргах, эрэн хайх, нүүлгэн шилжүүлэх, далан хаалт босгох, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг техник, тоног төхөөрөмжийн тусламжтайгаар гүйцэтгэхийг;

### *2.3. Техник, тоног төхөөрөмжийн нэр томъёо:*

2.3.1. “Аврах завь” гэж усан орчинд зориулагдсан хөвөгч хэрэгслийг;

2.3.2. “Аврах усан онгоц” (катер) гэж 6-аас дээш хүний багтаамжтай усны мандал дээгүүр явах залуурт хөдөлгүүртэй техникийг;

2.3.3. “Аврах хантааз” гэж уснаас аврах ажиллагаа явуулах үед аюулгүй байдлыг хангаж усан дээр хөвүүлэх хэрэгслийг;

2.3.4. “Аврах цагираг” гэж нэрвэгдэгсдийг уснаас гаргахад туслах, аврах хөвөгч хэрэгслийг;

2.3.5. “Аюултай бүсийн тэмдэг” гэж ослын голомтыг аюулгүй бүсээс ялгасан туузыг;

2.3.6. “Анхааруулах самбар” гэж гол, нуур, цөөрмийн усны түвшинг тогтоосон сэрэмжлүүлэх зорилго бүхий тэмдэглэгээтэй самбарыг;

- 2.3.7. “Алсын удирдлагатай шумбах төхөөрөмж” гэж усан доор хүний оролцоогүйгээр шумбаж тандах, аврах ажиллагаа гүйцэтгэх төхөөрөмжийг;
- 2.3.8. “Авиа мэдрэгч” (эхолот) гэж усан доорх объектыг дуу чимээний цуурай ашиглан илрүүлэх төхөөрөмжийг;
- 2.3.9. “Бортогны үүргэвч” гэж шумбагч болон бортогыг холбосон хэрэгслийг;
- 2.3.10. “Бортого цэнэглэгч төхөөрөмж” гэж гүний шумбагчийн бортого хүчилтөрөгчөөр цэнэглэх төхөөрөмжийг;
- 2.3.11. “Барокамер” гэж өндөр хийн даралтын орчинд хүний бие махбодоо дасгах зориулалттай өндөр битүүмжлэл бүхий даралтат зөөврийн болон суурин төхөөрөмжийг;
- 2.3.12. “Газар уснаа явагч” гэж газрын гадарга болон усны мандлаар явагч хөдөлгүүрт механизмыг;
- 2.3.13. “Гарын нэмэлт сэлүүр” гэж усны гүнд болон мандал дээр сэлэхэд хурд нэмэгдүүлэх өмсгөлийг;
- 2.3.14. “Дохионы олс” гэж усны гүний шумбагчтай холбоо тогтоох хэрэгслийг;
- 2.3.15. “Завины сэлүүр” гэж завийг усанд хөдөлгөх, залуурдах хэрэгслийг;
- 2.3.16. “Завины хөөрөг” гэж завь хийлэх шахуурга хэрэгслийг;
- 2.3.17. “Зангуу” гэж усны ёроолоос эрж хайх зориулалттай 3-4 талт дэгээг;
- 2.3.18. “Зуултуур” гэж хүчилтөрөгчөөр амьсгалах зориулалттай хэрэгслийг;
- 2.3.19. “Мандлын зуултуур” гэж усны нүдний шил бүхий гуурсан хоолойтой амьсгалах хэрэгслийг;
- 2.3.20. “Мөс цоологч өрөм” гэж гол, нуур, цөөрмийн хөлдсөн мөсийг цоологч хэрэгслийг;
- 2.3.21. “Нисгэгчгүй нисэх төхөөрөмж” гэж гэрэл зураг авах, дүрс бичлэг хийх хэрэгсэл бүхий бага оврын хөөрөх төхөөрөмжийг;
- 2.3.22. “Олс харвагч” (хавчаахай) гэж тодорхой зайнд олсоор харвах төхөөрөмжийг;
- 2.3.23. “Өргөх уут” гэж агаар өгч дээш хөвүүлэх зориулалттай хэрэгслийг;
- 2.3.24. “Скафандр” гэж усны гүнд удаан хугацаагаар ажиллах зориулалттай битүүмжлэл бүхий өмсгөлийг;
- 2.3.25. “Тэмтрүүл” гэж 3-4 метр урттай тэмтрэх, татах, дэгээдэх хэрэгслийг;
- 2.3.26. “Усчны хуурай хувцас” гэж шумбагчийн биеийг гаднах орчны нөлөөнөөс бүрэн хамгаалдаг ус, хий нэвтрүүлдэггүй өмсгөлийг;
- 2.3.27. “Усчны нойтон хувцас” гэж шумбагчийн биеийг гаднах орчны нөлөөнөөс хэсэгчлэн хамгаалдаг ус, хий нэвтрүүлдэг өмсгөлийг;
- 2.3.28. “Усчны мандлын хувцас” гэж усны мандал дээр ажиллахад хүйтнээс хамгаалах, биеийн дулааныг тогтмол хэмд барьж байх өмсгөлийг;
- 2.3.29. “Усчны дуулга” гэж аврагчдын толгойг хамгаалах өмсгөлийг;
- 2.3.30. “Усчны малгай” гэж толгойг хүйтнээс хамгаалах өмсгөлийг;
- 2.3.31. “Усчны бээлий” гэж гар хамгаалах өмсгөлийг;
- 2.3.32. “Усчны гутал” гэж хөл хамгаалах өмсгөлийг;
- 2.3.33. “Усчны нүдний шил” гэж шумбагчийн нүдийг хамгаалах, харах чадварыг сайжруулах өмсгөлийг;

- 2.3.34. “Усчны хутга” гэж усан орчинд таслах, огтлох зориулалттай хэрэгслийг;
- 2.3.35. “Усчны шүгэл” гэж дохио дамжуулах, даалгавар өгөх хэрэгслийг;
- 2.3.36. “Усчны цаг” гэж усны гүнд хугацаа тооцох тусгай зориулалтын цагийг;
- 2.3.37. “Усчны луужин” гэж усны гүнд зүг чиг баримжаалагч багажийг;
- 2.3.38. “Усчны гар чийдэн” гэж усан дотор орчныг гэрэлтүүлэх хэрэгслийг;
- 2.3.39. “Усчны цүнх” гэж ус нэвтэрдэггүй материалаар хийсэн уутыг;
- 2.3.40. “Усчны олс” гэж уснаас эрэн хайх, аврах ажиллагаанд хэрэглэх зориулалтын олсыг;
- 2.3.41. “Усчны мотоцикл” гэж 1-2 хүний багтаамжтай усны мандал дээгүүр явах залуурт хөдөлгүүртэй техникийг;
- 2.3.42. “Усчны дугуй” гэж 1-2 хүний багтаамжтай усны мандал дээгүүр явах залуурт механик хэрэгслийг;
- 2.3.43. “Усчны чарга” гэж усны мандал дээгүүр хөвж нэрвэгдэгсдэд тусламжийн зүйл урсган хүргэх зориулалттай хэрэгслийг;
- 2.3.44. “Усны даралт хэмжигч” гэж усны гүнд даралт хэмжих багажийг;
- 2.3.45. “Усны гүн хэмжигч” гэж усны гүнийг тодорхойлох багажийг;
- 2.3.46. “Усны гүний гэрэл зургийн хэрэгсэл” гэж усны гүнд гэрэл зураг авах зориулалттай хэрэгслийг;
- 2.3.47. “Усны гүний эрэл хайгуулын дуран” гэж усны гүнд эрэл хайгуул хийх зориулалтын багажийг;
- 2.3.48. “Хүчилтөрөгчийн бортого” гэж усны гүнд ажиллаж буй шумбагчийг хүчилтөрөгчөөр хангах хэрэгслийг;
- 2.3.49. “Хүчилтөрөгчийн хуваарилагч” гэж бортогоноос гарч буй агаарыг хуваарилах хэрэгслийг;
- 2.3.50. “Хүндрүүлэгч бүс” гэж усны гүнд шумбах ажиллагаа явуулах үед аврагчийн биеийн жинг нэмэгдүүлэх хэрэгслийг;
- 2.3.51. “Хөлийн нэмэлт сэлүүр” гэж усны гүнд болон мандал дээр сэлэхэд хурд нэмэгдүүлэх өмсгөлийг;
- 2.3.52. “Халаагч” гэж хүйтэн сэрүүн нөхцөлд байр, майхныг дулаацуулах хэрэгслийг;
- 2.3.53. “Шумбагч онгоц” гэж усны гүнд шумбаж явах зориулалттай өндөр битүүмжлэл бүхий хөдөлгүүрт техникийг;
- 2.3.54. “Шумбалтын иж бүрдэл” гэж усны гүн рүү шумбан аврах ажиллагаа явуулахад амьсгалын системийг дэмжих, ажиллах хугацааг уртасгах зориулалт бүхий иж бүрэн хэрэгслийг;
- 2.3.55. “Шумбалтын багаж” гэж ажлын бүтээмжийг дээшлүүлэх гар ажиллагаатай хэрэгслийг;
- 2.3.56. “Эрэн хайх, аврах тусгай зориулалтын автомашин” гэж уснаас эрэн хайх, аврах ажиллагааны тоног төхөөрөмж, хамгаалах хувцас хэрэгслээр тоноглогдсон техникийг;

## Гурав. Удирдлага, зохион байгуулалт

3.1. Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Аврах тусгай анги болон аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтсийн дарга, захирагч нь “Уснаас эрэн хайх, аврах бүлэг”-ийн бүрэлдэхүүнийг тушаалаар томилж үүрэгжүүлнэ. Үүнд:

- 3.1.1. бүлгийн дарга (аврах ажиллагааны удирдагч);
- 3.1.2. аврагч-усчин (шумбагч);
- 3.1.3. туслах-аврагч (шумбагч);
- 3.1.4. хамгаалагч-аврагч (шумбагч);
- 3.1.5. эмч-аврагч, эмнэлгийн зааварлагч;
- 3.1.6. аврагч-жолооч, холбоочин;

3.2. Төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтсийн дарга уснаас эрэн хайх, аврах ажиллагааны төлөвлөгөөг батлаж, үер, усны аюул, хэмжээ, ослын цар хүрээнээс хамаарч шаардагдах хүч хэрэгслийг нэмэгдүүлэх ажлыг хариуцан зохион байгуулна.

3.3. Аврах тусгай анги болон аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтсийн дарга, захирагч нь болзошгүй үер, уснаас эрэн хайх, аврах ажиллагаанд зарцуулагдах хүнс, шатахууны нөөцийг бүрдүүлсэн байна.

3.4. Аврах анги, салбарын захирагч (аврах ажиллагааны ахлах удирдагч) нь томилгоот аврах бүлгийг “Үндсэн”, “Бэлтгэл”, “Нэмэлт”, “Нөөц” хэлбэрээр зохион байгуулна.

3.5. Аврах анги, салбарын захирагч нь уснаас эрэн хайх, аврах ажиллагаа явуулах техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдал, албан хаагчдын үүрэг гүйцэтгэлтэд хяналт тавьж ажиллана.

3.6. Аврах анги, салбарын захирагч нь аврах ажиллагааны даалгаврын баримт бичгийн бүртгэл, техник, тоног төхөөрөмж, хамгаалах хувцасны ашиглалт, ажиллах цаг хугацаанд нь хяналт тавина.

3.7. Бүлгийн дарга (аврах ажиллагааны удирдагч) нь аврах анги, салбарын захирагчид захирагдана.

3.8. Уснаас эрэн хайх, аврах ажиллагааг анги, салбар, бүлгийн дарга, томилгоожсон туршлагатай мэргэшсэн аврагч удирдана.

3.9. Уснаас эрэн хайх, аврах бүлэг нь 2 хэсэг хуваагдаж ажиллах үед туршлагатай мэргэшсэн аврагч нэг хэсгийг бүлгийн даргын тушаалаар удирдана.

3.10. Хэн, юу осолдсон нь тодорхойгүй болон мэдээлэл нотлогдоогүй бодит бус тохиолдолд эрэн хайх, ажиллагааг гүйцэтгэхгүй.

3.11. Буцалтгүй нэрвэгдэгчийг эрэн хайж байгаа үед нэмэлт ослын дуудлага ирвэл аврах ажиллагааны удирдагчийн шийдвэрээр бүлгийн бүрэлдэхүүнийг бүрэн, эсхүл хэсэгчлэн шилжүүлж аврах ажиллагааг гүйцэтгэнэ.

3.12. Эхний бүлэг дуудлагаар ажиллаж байгаа үед дараагийн дуудлагаар ажиллах бэлтгэл, нэмэлт, нөөц бүлгийг анги, салбарын захирагч тодотгоно.

3.13. Уснаас эрэн хайх, аврах ажиллагаанд 2-оос дээш бүлэг оролцсон бол салбарын захирагч, 4-өөс дээш бүлэг оролцсон ажиллагааг ангийн захирагч удирдаж явуулна.

3.14. Ослын голомтод эхлэн ирсэн аврах бүлгийн дарга нь аврах ажиллагааны удирдагч байна.

3.15. Нэмэлтээр ирсэн бүлэг, салбарын дарга болон эрх бүхий албан тушаалтан удирдлагыг албан ёсоор шилжүүлэн аваагүй тохиолдолд эхний бүлгийн дарга удирдагч байна.

3.16. Ослын шинж байдал гадны нөлөөтэй, гэмт хэргийн шинж чанартай байж болзошгүй тохиолдолд цагдаа, прокурор, эмнэлгийн байгууллагын оролцоотойгоор ажиллагааг гүйцэтгэнэ.

3.17. Аварсан, осолдсон нэрвэгдэгчийг цагдаа, эмнэлгийн байгууллагад энэ журмын 2.1.1-т заасан баримт бичгийн дагуу шилжүүлэн өгнө.

3.18. Аюулгүй бүсэд гаргасан буцалтгүй нэрвэгдэгчийг цагдаагийн байгууллагад шилжүүлнэ.

3.19. Буцалтгүй нэрвэгдэгчийг тусгай зориулалтын автомашинаар болон зорчигчтой хамт зөөвөрлөхийг хориглоно.

3.20. Аймгийн хилийн цэс нэвтэрч уснаас эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах үед тухайн аймгийн онцгой байдлын байгууллагад мэдэгдэх бөгөөд шаардлагатай бол дэмжлэг авна.

3.21. Уснаас эрэн хайх, аврах ажиллагааг гүйцэтгэж байгаа аврах анги, салбарын үйлчлэх хүрээнээс гарч улсын хил нэвтэрч эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах тохиолдолд гадаад харилцаа, хил хамгаалах байгууллагын дэмжлэг, туслалцаа авна.

3.22. Ослын хор уршиг, хамрах хүрээ нь тухайн орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтсийн чадавхиас давсан тохиолдолд Аврах тусгай анги болон зэргэлдээ Онцгой байдлын газар, хэлтсээс уснаас эрэн хайх, аврах бүлгийг хүч нэмэгдүүлэн ажиллуулж болно.

3.23. Нутгийн захиргааны байгууллага нь өөрийн нутаг дэвсгэрт эрэн хайх, аврах ажиллагаа явуулж байгаа онцгой байдлын эрэн хайх, аврах бүлэгт дэмжлэг үзүүлнэ.

3.24. Эрэн хайх, аврах ажиллагааг ослын голомтод аль ойр байгаа нутгийн захиргаа, онцгой байдлын байгууллага харъяалал болон нутаг дэвсгэрийн хил хязгаараас үл хамааран зохион байгуулна.

3.25. Үер, усны аюулын хор уршгийг арилгах ажиллагаанд аж ахуйн нэгж, байгууллага, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн хүч хэрэгсэл, зэвсэгт хүчин, хил хамгаалах тусгай зориулалтын анги, салбарыг оролцуулж болно.

3.26. Эрэн хайх, аврах ажиллагааг газар орны байршил, үүссэн нөхцөл байдлаас шалтгаалан үргэлжлэх хугацааг бүлгийн дарга (аврах ажиллагааны удирдагч) тогтоож шаардлагатай тохиолдолд нэрвэгдэгсэд болон ар гэрт (хоол хүнс, шатахуун)-ын дэмжлэг үзүүлэх ажиллагааг зохион байгуулна.

#### Дөрөв. Албан тушаалтны эрх, үүрэг

##### 4.1. Бүлгийн дарга (аврах ажиллагааны удирдагч)-ийн эрх, үүрэг

4.1.1. бүлгийн бие бүрэлдэхүүнийг аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажилд сургаж, бэлтгэх;



4.1.2. ослын хор уршгийг арилгах төлөвлөгөө боловсруулах, ажиллагаанд шаардагдах төсвийг тооцоолон гаргаж, холбогдох баримт, бичгийг бүрдүүлэх;

4.1.3. бүлгийн бие бүрэлдэхүүний тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмжийн иж бүрдлийг үүрэг гүйцэтгэхэд бэлэн болгох, үзлэг хийж, зөрчлийг арилгуулах;

4.1.4. ослын голомтод үүрэг гүйцэтгэх бүрэлдэхүүнийг тодотгож, үүссэн нөхцөл байдлыг тодорхой танилцуулж, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх;

4.1.5. ослын голомтод тээврийн хэрэгсэл хүрэлцэн очих зам гарц гаргах үүрэг гүйцэтгэж байгаа аврагч-усчин, шумбагчийн аюулгүй ажиллагаанд хяналт тавих;

4.1.6. ослын голомтод үүссэн цагийн байдалтай уялдуулж шаардлагатай хүч, хэрэгслээр хангах ажиллагааг зохион байгуулах;

4.1.7. шаардлагатай нөхцөл байдал үүссэн үед холбогдох хууль, хяналтын байгууллагад хэргийн газарт үзлэг хийх боломжийг хангах ажлыг зохион байгуулах;

4.1.8. усанд осолдсон нэрвэгдэгсдэд эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх ажлыг зохион байгуулах;

4.1.9. нөхцөл байдлын мэдээг харъяа төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтсийн жижүүрт танилцуулах;

4.1.10. ослын шалтгаан, нөхцөл байдал болон авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар аврах ажиллагааны даалгаврын биелэлт хөтлөж, илтгэх хуудас бичиж харъяа бүтцийн нэгжийн даргад танилцуулах;

4.1.11. усны гүний даралтаас гарах ажлын хугацааны тооцоог гаргаж, хүчилтөрөгчийн нөөцийг тодорхойлон ажиллах хугацааг тогтоох;

4.1.12. ажлын явцын талаар гүний шумбалтын бүртгэлийн дэвтэрт бичилт хийх;

4.1.13. шаардлагатай үед шумбагчийн өмсгөлийг өмсүүлэх, тусламж үзүүлэх;

4.1.14. ажиллаж буй шумбагч болон аврах бүлгийн гишүүд үүргээ бүрэн биелүүлж байгаа эсэхийг хянах, зааварчлах;

4.1.15. усны гүнд ажиллах 5.4.4-дэх эрсдлүүдийг тооцох;

4.1.16. ажиллаж буй шумбагчийг даалгавраа гүйцэтгэсний дараа гадаргуу дээр гарах зөвшөөрөл олгох, эмч-аврагчийн сонгосон даралтаас дэглэмийн дагуу гаргах;

4.1.17. шумбагчийг өргөх үеийн даралтаас гарах дэглэм болон өргөлтийн хурдыг анхаарах;

4.1.18. аврах ажиллагааны даалгаврыг биелүүлсэний дараа ажлын гүйцэтгэлийг /2 дугаар хавсралт/ баримтжуулах;

#### *4.2. Аврагч-усчин (шумбагч)-ийн эрх, үүрэг*

- 4.2.1. аврах ажиллагааны арга технологийг эзэмшиж, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг зааврын дагуу ашиглах мэдлэг чадвартай байх;
- 4.2.2. хариуцсан тусгай зориулалтын хамгаалах хувцас, хэрэгслийн бэлэн байдлыг хангах;
- 4.2.3. ослын голомтыг судалж бүлгийн даргын тушаалаар эрэн хайх, аврах ажиллагаа гүйцэтгэх;
- 4.2.4. хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зааварчилгааг баримталж ажиллах;
- 4.2.5. эрэн хайх, аврах ажиллагааны үед гарсан алдаа, зөрчил дутагдлын талаар бүлгийн даргад яаралтай мэдэгдэх;
- 4.2.6. усны гүний даралтаас гарах дэглэмийн дагуу, усны гүнрүү орох болон гүнээс гарахдаа заагдсан метрт, тогтоосон хугацаанд түр зогсолтыг гүйцэтгэх;

#### *4.3. Туслах-аврагч (шумбагч)-ийн эрх, үүрэг*

- 4.3.1. шумбагчийн өмсгөлийг зөв дараалалтай өмсгөх;
- 4.3.2. шумбалтын иж бүрдлийг шалгах;
- 4.3.3. шумбаж буй гүний шумбагчийн аюулгүй байдлыг хангах;
- 4.3.4. дохионы олсоор тогтмол (5 минутаас доошгүй) давтамжтай шумбалтын бүх хугацаанд ажиллаж буй шумбагчийн биеийн байдлыг магадлах;
- 4.3.5. ажиллаж буй шумбагч 2 удаа өгсөн дохионд хариулахгүй бол аврах ажиллагааны удирдагчид нэн даруй мэдэгдэх;
- 4.3.6. ажиллаж буй шумбагчаас ослын дохио ирсэн тохиолдолд аврах ажиллагааны удирдагчид нэн даруй мэдэгдэх;
- 4.3.7. осолдсон шумбагчид тусламж үзүүлэхээр хамгаалагч шумбагч усны гүнд орсон нөхцөлд түүний үйлдлийг хянах;
- 4.3.8. ажиллаж буй шумбагчийг усны мандал дээр гарахад өмсгөлийг нь тайлахад туслах;
- 4.3.9. туслах шумбагч аврах ажиллагааны удирдагчийн зөвшөөрөлгүй дохионы татлагыг бусдад үл шилжүүлэх;
- 4.3.10. дохионы олс хариуцаж буй туслах шумбагч ээлжээ шилжүүлэх нөхцөлд усан доор ажиллаж буй шумбагчид «Бие нь сайн уу?» гэсэн дохиог ээлжийг нь хүлээн авч буй шумбагчийн дэргэд өгөөд дохионы татлагыг дамжуулна. «Сайн байна» гэсэн хариу дохио авсаны дараа аврах ажиллагааны удирдагчид ээлжээ шилжүүлсэнээ мэдэгдэх;
- 4.3.11. ажиллагааны явцад бүлэгт шаардлагатай хоол, хүнс, дулаацах байр, бэлтгэх асуудлыг хариуцах;
- 4.3.12. ажиллаж буй шумбагчийг орлож ажиллахад бэлэн байх;

#### *4.4.Хамгаалагч-аврагч (шумбагч)-ийн эрх, үүрэг*

- 4.4.1. хамгаалагч шумбагч осолд орсон шумбагчид нэн даруй туслах;
- 4.4.2. өөрийн гүний шумбалтын хэрэгсэлд ажлын шалгалт хийж гүний шумбалтын дэвтэрт тэмдэглэж гарын үсгээ зурж аврах ажиллагааны удирдагчид мэдэгдэх;
- 4.4.3. шумбалтын гүн, шумбалтын иж бүрдэлтэй ажиллах хугацаанаас хамааран ажиллаж буй шумбагчийн усан доор байх хугацааг анхааран ажиглаж 5 минут тутам аврах ажиллагааны удирдагчид мэдэгдэх;
- 4.4.4. аюул тулгарсан шумбагчид тусламж үзүүлэхэд байнга бэлэн байх;
- 4.4.5. ажиллаж буй шумбагчаас ослын дохио авмагц түүнд тусламж үзүүлэхээр аврах ажиллагааны удирдагчийн тушаалаар усны гүнд орох;
- 4.4.6. хамгаалагч-аврагч шумбагчийг шумбалтын өмнө барокамерын бэлэн байдлыг шалгах;
- 4.4.7. ажиллагааны үед хамгаалагч шумбагч үүрэг гүйцэтгэх тушаалыг хүлээж, шумбалтын хувцас, тоноглолтой бэлэн байх;
- 4.4.8. шаардлагатай тохиолдолд усны гүнд орж ажиллаж буй шумбагчдыг хамгаалах;

#### *4.5. Эмч-аврагч, эмнэлгийн зааварлагчийн эрх, үүрэг*

- 4.5.1 шумбагчийн амьсгалын тогтолцоо, зүрх судасны үйл ажиллагаа, судасны цохилт, арьсны эмгэг, хараа, сонсгол, согтууруулах ундаа хэрэглэсэн эсэхийг шалгах;
- 4.5.2. ослын голомтод нэрвэгдэгсдэд болон бүлгийн бие бүрэлдэхүүний эрүүл мэндийн байдалд хяналт тавьж, анхны тусламж үзүүлэх;
- 4.5.3. шумбагчийн эрүүл мэндийн байдалд шумбалтын өмнө ба дараа нь үнэлгээ өгнө;
- 4.5.4. шаардлагатай үед нэрвэгдэгсдийг тээвэрлэж 2, 3 дугаар шатлалын эмнэлэгт хүргэх;
- 4.5.5. шумбалтын ажиллагааны үед эмнэлгийн тусламжийн эм, эмийн хэрэгслээр хангах;
- 4.5.6. усны их гүнд шумбах шумбагчийг барокамерт оруулж даралтыг тэнцвэржүүлэх;
- 4.5.7. шумбагчид кессоны өвчин илэрвэл барокамерт эмчилгээний дэглэмийн дагуу эмчлэх;
- 4.5.8. эрүүл мэндийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1.3.-т заасны дагуу /хөдөлмөр, эрүүл ахуйн нөхцөлийг эрүүлжүүлэх, хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулах арга хэмжээ авч, аливаа өвчин, ялангуяа хордлого, халдвар, осол, гэмтэл, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрх бүхий байгууллагаас баталсан эрүүл ахуйн стандарт, хэм хэмжээ, журмыг чанд сахин биелүүлэх/ ажиллаж буй шумбагчдад эрүүл мэндийг хамгаалах үйлчилгээ үзүүлэх;

#### *4.6. Аврагч-жолооч, холбоочны эрх, үүрэг*

4.6.1. эрэн хайх, аврах бүлгийн бүрэлдэхүүн, техник хэрэгслийг ослын голомтод шуурхай хүргэх, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, техник хэрэгслийн бэлэн байдлыг хариуцах;

4.6.2. ослын голомтод авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх мэдээллийг ахлах даргад тухай бүрт шуурхай хүргэж, холбоог зохион байгуулах;

4.6.3. ажиллагааны үеэр гүний шумбалтын хэрэгсэлд доголдол илэрсэн тохиолдолд шуурхай засах, ямар арга хэмжээ авсан талаар дүрс бичлэг, гэрэл зургаар баримтжуулах;

4.6.4. ослын голомтод аюултай бүсийн тэмдэглэгээний туузыг бүлгийн даргын тушаалаар татаж, хяналт тавих;

Тав. Уснаас эрэн хайх, аврах ажиллагаа

#### *5.1. Урсгал уснаас эрэн хайх, аврах ажиллагаа:*

5.1.1. аврах бүлэг нь үер, усанд урссан, живж буй нэрвэгдэгсдийг голын хоёр эргийн хооронд олсоор татлага татаж чарга урсгах, урсгалын дээрээс завиар очих, тосож татан гаргах, аврагч аврах, нисдэг тэрэг, нисгэгчгүй нисэх төхөөрөмж бусад техник хэрэгслээр авран туслах үйл ажиллагааг явуулна;

5.1.2. урсгал усанд ажиллагаа явуулахад завь заавал байх, шумбалт хийх усны урсгал дээр завийг байрлуулж, завийг тогтсон үед шумбалтыг явуулна;

5.1.3. урссан, живсэн нэрвэгдэгсдийг голын голдирол, хаялага, харгиа, эрэг, эргүүл, гол нуурын мод, хог бөөгнөрсөн газар тэмтрүүл, зангуу ашиглан завьтай эрлийг явуулах;

5.1.4. аврах бүлэг урсгал уснаас эрэн хайх, аврах ажиллагааг гүйцэтгэхдээ аюулгүй ажиллагааны зааврыг баримтлан үүрэг гүйцэтгэнэ;

5.1.5. урсгал сөргүүлж аврагчийг болон завь, техникийг аврах олс, татлагаар татахыг хориглоно;

5.1.6. үерийн аюултай ширүүн урсацтай үед дээрээс татах (нисдэг тэрэг, өргөгч, чарга явуулах, татуурга татах) ажиллагаанаас бусад усанд сэлэх, завьтай орохыг хориглоно;

#### *5.2. Усны гүнээс эрэн хайх, аврах ажиллагаа:*

5.2.1. усны гүнээс эрэн хайх, аврах үйл ажиллагааг тандалтын мэдээг үндэслэж зохион байгуулна;

5.2.2. усны гүнд эрэн хайх ажиллагааг явуулахдаа тандалтын шумбалтыг мэргэшсэн шумбагч гүйцэтгэнэ;

5.2.3. аврах ажиллагааны шумбалтыг хоёроос доошгүй шумбагч гүйцэтгэх;

5.2.4. тогтмол ус, нуур цөөрөмд унасан хүн ёроолд нь байгаа тохиолдолд усчны хуурай хувцастай, шумбалтын нүдний шил, хөлийн нэмэлт сэлүүр хэрэглэн аврагчийг нарийн олсоор холбон оосорлон оруулж аврах ажлыг аюулгүйн ажиллагааны дагуу гүйцэтгэнэ.

5.2.5. туслах шумбагч усны мандал дээрээс ажиллаж буй шумбагчийг ажиглаж олсоор харилцах бөгөөд гар дохиогоор бүлгийн даргатай харьцана;

5.2.6. аврах бүлэг шумбалтын хэрэгсэлтэй уснаас эрэн хайх, аврах ажиллагааг гүйцэтгэхдээ аюулгүй ажиллагааны зааврыг баримтлан үүрэг гүйцэтгэнэ;

5.2.7. усны гүнд тандалтыг тэмтрүүл, зангуу, тусгай зориулалттай усны дуран, алсын удирдлагатай шумбагч төхөөрөмж ашиглана;

5.2.8. усны гүнээс хүн болон автомашиныг (техник, бусад) татан гаргах ажиллагааг гүйцэтгэнэ;

5.2.9. усны их гүнд шумбалт гүйцэтгэх аврагч барокамерт орж даралтыг тэнцвэржүүлсэн байна;

5.2.10. усны дунд гүнд газар зүйн байрлал, усны найрлага, шинж чанар зэрэг онцлогыг харгалзан барокамерт орж даралтыг тэнцвэржүүлж болно;

### *5.3. Мөс цөмөрсөн үеийн эрэн хайх, аврах ажиллагаа:*

5.3.1. аврах ажиллагаанд завийг хийлж бэлэн байлгах;

5.3.2. аврах ажиллагаа явуулахдаа нэрвэгдэгсдэд олс, мод, цагираг шидэн өгч, татан гаргана;

5.3.3. ажиллагааны үеэр урт модон шат, банз, шургааг зэрэг талбай ихтэй, даралт багатай эд зүйлсийг ашиглана;

5.3.4. шумбалтыг эхлэхийн өмнө дулаацах байр бэлтгэнэ;

5.3.5. мөс цоологч өрөм, цахилгаан хөрөө ашиглаж (мөсний зузаан болон нягтралыг хэмжих, тэсрэх бодис байрлуулах) нүх, цооног гаргана;

5.3.6. шумбалт хийхийн тулд 2х2 метрийн хэмжээтэй гурвалжин цооног гаргаж, банзаар тойруулан хашлага тавина;

5.3.7. мөсний гадаргууд ан цав, ус гарвал гүний шумбалтыг зогсооно;

5.3.8. цөн түрсэн, цас мөс ихтэй усан орчинд аврагч усанд эрэн хайх, ажиллагаа явуулахыг хориглоно;

5.3.9. мөсөн доогуур урсалтай үед хөндлөн шумбах ажиллагаа гүйцэтгэхийг хориглоно;

5.3.10. мөсөн дээрх даацын тооцоог хэтрүүлэхийг хориглоно;

5.3.11. аюулгүй байдлыг хангаж, нарийвчилсан тооцоо, судалгааг үндэслэн мөсийг тэслэх, дэлбэлэх ажиллагааг гүйцэтгэж болно;

5.3.12. мөсөнд зурвас гарган усанд живсэн (автомашин) эд зүйлийг гаргана;

### *5.4. Үзэгдэх орчин хязгаарлагдмал үеийн аврах ажиллагаа:*

5.4.1. аврагч шөнийн цагаар харанхуй орчинд ажиллахдаа зайгаар ажилладаг тусгалтай, гэрлэн тоноглолтой малгайтай байна;

5.4.2. эрэн хайх, аврах ажиллагааг гүйцэтгэхэд тус болох биеийн дулаан мэдэрдэг болон усны дуран, шөнө дүрс ялган харах чадал бүхий техник хэрэгсэл ашиглана;

5.4.3. цасан болон шороон шуурга, ширүүн бороотой нөхцөлд аврагчид тусгай зориулалтын нүдний хамгаалалтын шилтэй байна;

5.4.4. ажиллах орчин тодорхой бус, хяналт тавих боломжгүй, унанга, урсгал ширүүн, барилгын тодорхой бус хийц, зүг чиг баримжаагүй зэрэг аюултай байж болзошгүй нөхцөлд ажиллагааг түр зогсооно;

5.4.5. усны гүний шумбалтын ажиллагааг задгай хяналт тавих боломжтой нуур, цөөрөм, урсгал бус тогтмол устай үед шумбалтыг ажиллагааг (10-15 метрийн тойрогт тусаж байх) гэрэлтүүлэгтэй зохион байгуулна;

5.4.6. шаардлагатай нөхцөлд буюу нэрвэгдэгч амьд үед аврах ажиллагааг зохион байгуулна.

*5.5. Нисдэг тэрэг, нисгэгчгүй нисэх төхөөрөмж, хүнд механизм ашиглаж аврах ажиллагаа:*

5.5.1. эрэн хайх, ажиллагааны үед нисдэг тэргээр ажиглалтыг ил хараа болон тусгай хэрэгслээр явуулах;

5.5.2. аврах ажиллагаанд хүнд механизмыг техникийн хүчин чадалд тохирсон үзүүлэлтээр нь ашиглах;

5.5.3. нисгэгчгүй нисэх төхөөрөмжийг тусгай зааврын дагуу ашиглах;

*5.6. Нүүлгэн шилжүүлэх, далан хаалт босгох ажиллагаа:*

5.6.1. аврах бүлэг үерийн голомтоос хүн амыг завь, автомашин, нисдэг тэргэнд хүмүүсийг суулган тээвэрлэх;

5.6.2. нүүлгэн шилжүүлэх үед аврах бүлэг ард, иргэдэд тухай бүрт нь шаардлагатай заавар, зөвлөгөөг өгөх;

5.6.3. нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа явуулж байгаа бусад мэргэжлийн ангитай байнгын уялдаа холбоотой ажиллах;

5.6.4. үерээс хамгаалах далан хаалт сэтрэх, яаралтай далан босгох мэргэжлийн ангийн ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

*Зургаа. Хөдөлмөр хамгаалал, аюулгүйн ажиллагаа, мэргэжлийн сургалт, дадлага*

*6.1. Хөдөлмөр, хамгаалал, аюулгүй ажиллагаа*

6.1.1. уснаас эрэн хайх, аврах ажиллагаанаас гадна хөндлөнгийн иргэн, нэрвэгдэгчийн ар гэрээс дур мэдэн аврах завин дээр суух, усанд сэлэх, ажиллагаа зохион байгуулахыг хориглоно.

6.1.2. онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын “Хөдөлмөр, хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм”-ийг уснаас эрэн хайх, аврах ажиллагаанд удирдлага болгоно.

6.1.3. уснаас эрэн хайх, аврах ажиллагааны онцлогоос шалтгаалан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дараах зохион байгуулалтыг баримтлана. Үүнд:

6.1.3.1. тухайн орон нутгийн захиргаа болон Онцгой байдлын газар, хэлтсийн удирдлага нь анги, салбарыг эрэн хайх, аврах тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас, багаж, хэрэгслээр хангасан /1 дүгээр хавсралт/ байна;

6.1.3.2. анги, салбарын захирагч эрэн хайх, аврах тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас, багаж, хэрэгслийн баталгаажилтыг хариуцаж хөдөлмөр хамгаалал, аюулгүйн зааварчилгааг улирал бүр аврах бүлэгт өгч, биелэлтэд хяналт тавина;

6.1.3.3. бүлгийн дарга эрэн хайх, аврах тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас, багаж, хэрэгслийн ашиглалтыг хариуцаж хөдөлмөр хамгаалал, аюулгүйн зааварчилгааг сар бүр аврагч нарт өгч, биелэлтэд хяналт тавина;

6.1.3.4. аврагч хариуцсан эрэн хайх, аврах тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас, багаж, хэрэгслийн бэлэн байдлыг хариуцаж хөдөлмөр хамгаалал, аюулгүйн зааварчилгааг авч биелэлтийг шадар даргад тайлагнах;

6.1.4. хүн нэг бүрийн хамгаалах тусгай хувцас, багаж хэрэгсэл ашиглалтын шаардлага хангахгүй тохиолдолд ашиглахыг хориглоно;

6.1.5. тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас, багаж хэрэгслийг техникийн тодорхойлолтын дагуу хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааврын дагуу ашиглана.

6.1.6. эрүүл мэндийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1.4-т заасны дагуу /хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага уг нөлөөллөөс сэргийлэн хамгаалах арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг жил бүр төсөв, төлөвлөгөөндөө тусгаж, үйлдвэрлэл, үйлчилгээний эрүүл ахуй, технологийн нөхцөл, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаандаа зарцуулах/ төв, орон нутгийн онцгой байдлын анги, байгууллагын дарга нь эмч-аврагч, эмнэлгийн зааварлагчийн дүгнэлтийг үндэслэн аврагч-усчин, шумбагчийг улирал бүр эрүүл мэндийн нарийн мэргэжлийн үзлэгт хамруулах бөгөөд шаардлагатай үед эмчлүүлэх;

6.1.7. эмч-аврагч, эмнэлгийн зааварлагч нь гамшгийн голомтод аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааны дараа албан хаагчийг амрах, сувилах, эмчлүүлэхийг төв, орон нутгийн онцгой байдлын анги, байгууллагын даргад уламжлахын зэрэгцээ анги, салбарын байрлалд үүрэг гүйцэтгэсэн бүлгийн бүрэлдэхүүний бэлтгэл, нэмэлт, нөөц бүлгийн ажилласан нөхцөл байдлыг харгалзана.

## *6.2. Мэргэжлийн сургалт, дадлага*

6.2.1. онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагаас шумбалтын мэргэжлийн үнэлгээний ажлын хэсэг томилогдож аврагч-усчин, шумбагч нарт мэргэжлийн зэрэг олгох, мэргэшүүлэх болон гадаад, дотоодын удирдах, гүйцэтгэх ангилалын сургалтыг зохион байгуулах;

6.2.2. онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын сургалтын төлөвлөгөөний дагуу Аврах тусгай анги болон аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтсийн дарга, захирагчийн тушаалаар уснаас эрэн хайх, аврах ажиллагааны дадлага, сургуулийг жилд 2 удаа зун, өвлийн нөхцөлд хээрийн

гаралтаар 10-аас доошгүй хоногоор шаардлагатай хүнс, шатахуун, бусад зүйлсээр хангаж зохион байгуулна;

6.2.3. анги, салбарын захирагч сар бүр анги, салбараар ажиллахад бэлтгэсэн байна;

6.2.4. аврах бүлгийн дарга өдөр бүр бүлгийг багаар ажиллахад бэлтгэсэн байна;

6.2.5. аврагч-усчин (шумбагч) нь гүний шумбалтын сургууль, дамжаа төгссөн гэрчилгээ, шумбагчийн хувийн дэвтэр, шумбагчийн эмнэлгийн үзлэгээр орсон (эерэг тэмдэглэлтэй) эрүүл мэндийн дэвтэртэй байна;

6.2.6. мэргэжлийн тусгай сургалтын хөтөлбөрийн дагуу усан сангийн сургалтад хамрагдана;

6.2.7. улиралд 2-оос доошгүй удаа барокамерт эмч-аврагч, эмнэлгийн зааварлагчийн хяналтанд даралт тэнцвэржүүлэх бэлтгэл хийгдсэн байна;

#### Долоо. Томилолт, урамшуулал

7.1. уснаас эрэн хайх, аврах бүлгийн томилолт, урамшууллын зардлыг “Гамшгаас хамгаалах тухай” хуулийн 33 дугаар зүйлийн 33.3, Монгол Улсын Шадар сайд, Сангийн сайдын 2011 оны 47/186 дугаар тушаалаар баталсан “Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослын үед аврах ажиллагаа явуулсан Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын албан хаагч болон иргэнд урамшуулал олгох журам”-ын 2.1, 2.2, 3.1-т заасны дагуу олгоно.

#### Найм. Хяналт, хариуцлага

8.1. Хүний амь нас, эрүүл мэнд хохирох, байгаль орчин, мал, амьтанд хор уршиг учирсан тохиолдолд холбогдох хуулийн дагуу буруутай иргэн, аж ахуйн нэгж эрэн хайх, аврах ажиллагааны зардлыг хариуцан тухайн орон нутгийн захиргаанд барагдуулна.

8.2. “Уснаас эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах журам”-ын хэрэгжилтэнд Аврах тусгай анги, аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтсийн дарга, захирагч нар хяналт тавьж ажиллана.

8.3. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

-----oOo-----



“Уснаас эрэн хайх, аврах ажиллагааг зохион  
байгуулах журам”-ын 1 дүгээр хавсралт

УСНААС ЭРЭН ХАЙХ, АВРАХ БҮЛГИЙН ХҮЧ ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ

д/д	Хүч хэрэгслийн нэр	Тоо
Бүлгийн бие бүрэлдэхүүн		
1.	Бүлгийн дарга(аврах ажиллагааны удирдагч)	1
2.	Аврагч-усчин (шумбагч)	3-4
3.	Эмч-аврагч, эмнэлгийн зааварлагч	1
4.	Аврагч-жолооч, холбоочин	1-2
Нийт		6-8
А. Бүлгийн иж бүрдэл		
1.	Аврах тоног төхөөрөмж, хамгаалах хэрэгслээр тоноглогдсон автомашин	2 нэгж
2.	Аврах завь 8-12 хүний хийлдэг (сэнс, тийрэлт хөдөлгүүр)	2 ш
3.	Аврах усан онгоц (катер)	1 ш
4.	Аврах хантааз	8 ш
5.	Аврах цагираг	2 ш
6.	Аврах олс харвагч төхөөрөмж (хавчаахай)	1 иж
7.	Алсын удирдлагатай шумбах төхөөрөмж	1 ш
8.	Аяны майхан	3 иж
9.	Аяны гал тогооны хэрэгсэл	1 иж
10.	Байршил тогтоогч (GPS)	1 ш
11.	Барокамер	1 ш
12.	Бортого цэнэглэгч төхөөрөмж	1 иж
13.	Бүлэг дэхь нэрвэгдэгсдийн эмийн сан	1 иж
14.	Завины хөөрөг	1 иж
15.	Завины сэлүүр	6 ш
16.	Зангуу	1 ш
17.	Зөөврийн гар чийдэн (ус нэвтрүүлдэггүй)	2 ш
18.	Мөс цоологч өрөм	1 ш
19.	Инженерийн том, жижиг хүрз	Тус бүр 6 ш (12 ш)
20.	Нисгэгчгүй нисэх төхөөрөмж	1 ш
21.	2 нүдний шөнийн дуран (ус нэвтрүүлдэггүй)	1 ш
22.	2 нүдний ердийн дуран (ус нэвтрүүлдэггүй)	1 ш
23.	Сансрын холбооны утас (ус нэвтрүүлдэггүй)	1 иж
24.	Тэмтрүүл (3-4 метр урт)	1 ш

25.	Усчны дуулга	8 ш
26.	Усчны олс (100, 50, 30, 20 метр) - 200 метр	Тус бүр 4 ш (800 метр)
27.	Усчны гар чийдэн	8 ш
28.	Усчны чарга	1 ш
29.	Усчны мотоцикл	1 ш
30.	Усчны гүний гэрэл зургийн хэрэглэл	1 ш
31.	Усчны гүнд хайгуул хийх дуран	1 ш
32.	Ус сорогч, шахагч, дахин дамжуулагч (мотопомп)	1 иж
33.	Хүн нэг бүрийн тусгай хамгаалах хувцас хэрэгсэл (Мандлын болон гүний хувцас)	8 ш
34.	Хоолны халуун сав (10 литр)	1 иж
35.	Халаагч	1 иж
36.	Цахилгаан үүсгүүр (50 метрийн уртасгагч 2 ш, зөөврийн гэрэл 1ш)	1 ш
37.	Шумбалтын иж бүрдэл	4 иж
38.	Авиа мэдрэгч (эхолот), (усны гүнд дуу чимээний цуурай ашиглан объект илрүүлэгч)	1 ш
39.	Эвхдэг дамнуурга	1 ш
<b>Б. Аврагч-усчны иж бүрдэл</b>		
1.	Ажлын тусгай хувцас	1 ш
2.	Аврагчийн бээлий	2 ш
3.	Аврагчийн бүс	1 ш
4.	Аврагчийн шуудаг	1 ш
5.	Аврагчийн хантааз (тусгай хэрэгсэлтэй)	1 ш
6.	Аврагчийн үүргэвч: (усны гутал, борооны цув, аяны хөнжил, хоолны тогоо, дашмаг г.м)	1 ш
7.	Ариун цэврийн хэрэгсэл (оо, сойз, алчуур, саван, шумуулын тос г.м)	1 иж
8.	Амьсгал хамгаалах шүүгч баг	1 ш
9.	Арьс хамгаалах хувцас (Л-1)	1 ш
10.	Бүрх малгай (шумуулаас хамгаалах торон хаалттай)	1 ш
11.	Бэхэлгээний бага хэмжээний хамгаалалтын 3-5 метр олс 2 карбинтай	1 ш
12.	Гутал (хагас түрийт)	1 хос
13.	Гар радио станц	1 ш
14.	Гар чийдэн	1 ш
15.	Дуулга малгай, духны гэрэлтүүлэгтэй	1 ш
16.	Дулаан хувцас (өмд, хүрэм)	1 хос
17.	Дохио дамжуулах шүгэл	1 ш
18.	Жижиг байлдааны сүх (гэртэй)	1 ш
19.	Жижиг байлдааны хүрз (гэртэй)	1 ш

20.	Зуны богино өмд, цамц, улавч (ОБА, Аврагч гэсэн бичиглэлтэй)	1 хос
21.	Ноосон малгай	1 ш
22.	Нэрвэгдэгсдийн эмийн сан: ороох боох материал хөвөн, бинт, спирт, иод, түлэнхийн тос, халууны шил, чангалуур, өвчин намдаах эмнүүд нэг удаагийн резинэн бээлий, амны хаалт г.м	1 иж
23.	Өөрийн биед таарсан усчны нойтон, хуурай хувцас тус бүр	1 ш
24.	Өвдгөвч, тохойвч	1 ш
25.	Усчны цаг	1 ш
26.	Усчны хутга	1 ш
27.	Усчны нүдний шил	1 ш
28.	Хамгаалалтын нүдний шил (нурангийн)	1 ш
29.	Хутга болон олон ажиллагаатай хутга (гэртэй)	1 ш
<b>В. Шаардлагатай тохиолдолд ажиллах тусгай техник, багаж хэрэгсэл</b>		
1.	Даралтад болон гар ажиллагаатай багаж - Тасдагч - Тэлэгч - Хос ажиллагаатай хайч - Огтлогч - Хавтан бутлагч - Нимгэн тэлэгч - Өргөгч (50 тн)	1 иж
2.	Өндрийн ажиллагааны иж бүрдэл	1 иж
3.	Цахилгаан хөрөө	1 ш
<b>Г.Өндрийн ажиллагаа иж бүрдэл</b>		
1.	Аврах олс (10, 20, 50,100 м)-720 м	Тус бүр 4 ш (2880 метр)
2.	Аврах шуудаг	6 ш
3.	Буулгагч (8-н тоо)	6 ш
4.	Жумар (баруун, зүүн)	6 хос
5.	Зогсоогч	6 ш
6.	Карбин	32 ш
7.	Салаалагч (баавгайн савар)	6 ш
8.	Эвхдэг шат ( 5 метр)	1 ш
<b>Д. Автомашины нэмэлт тоноглол</b>		
1.	Автомашинд суурилагдсан ачаа	1 ш
2.	Автомашины хэт богино долгионы радио станц	1 ш
3.	Аврах шат (эвхдэг)	1 ш
4.	Амьсгалын төхөөрөмж (эмнэлгийн)	1 ш
5.	Аврах бүтээлэг (нэрвэгдэгсэдийн)	8 ш

6.	“Аюултай бүс” тэмдэглэгээ (500 метр)	1 ш
7.	Байршил тогтооч- (GPS-дэлгэцтэй)	1 ш
8.	Буцалтгүй нэрвэгдэгчийн (цогцос)-н уут	50 ш
9.	Гар радио станц (чихэвчтэй)	8 иж
10.	Гадна гэрэлтүүлэг (урд, хойд талд) дотроос удирдах	1 иж
11.	Гал унтраагуур	2 ш
12.	Дуут дохио (чанга яригчтай)	1 ш
13.	Татагч (лебёдка)	1 ш
14.	Татлага (15 мм-ийн 15 метр урт ган тросс)	1 ш
15.	Торхон дамнуурга	1 ш
16.	Жолоочийн багаж	1 иж
17.	Лоом	2 ш
18.	Эмнэлгийн тусламжийн гар цүнх (ороох боох материал г.м)	1 ш

**“Уснаас эрэн хайх, аврах ажиллагааны  
журам”-ын 2 дугаар хавсралт**

БАТЛАВ:  
ГАЗАР, ХЭЛТСТИЙН ДАРГА,

**АВРАХ АЖИЛЛАГААНЫ ДААЛГАВАР №**

.....оны.....сарын.....өдөр

**1. Ослын хаяг:**

20.... оны ..... дугаар сарын ..... -ний өдөр .....хот, аймгийн  
.....сум, дүүрэг, хорооны нутаг дэвсгэрт .....  
газарт гарсан.....  
.....  
.....  
/үер усны, нуранги, хими, эрэл/ ослын голомтод үүрэг гүйцэтгэхээр томилов.

**2. ТОМИЛОЛТООР АЖИЛЛАХ БҮРЭЛДЭХҮҮН:**

Бүлгийн дарга (аврах ажиллагааны удирдагч) .....  
Аврагч-жолооч, холбоочны нэр.....  
Эмч-аврагч, зааварлагчийн нэр.....  
Тусгай зориулалтын автомашины маяг, дугаар .....

Бүрэлдэхүүний нэрс:

- |         |          |
|---------|----------|
| 1. .... | 9. ....  |
| 2. .... | 10. .... |
| 3. .... | 11. .... |
| 4. .... | 12. .... |
| 5. .... | 13. .... |
| 6. .... | 14. .... |
| 7. .... | 15. .... |
| 8. .... | 16. .... |

**3.Аврах ажиллагаанд оролцох аврагч нарт хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа танилцуулсан хүснэгт:**

Д/д	Цол	Албан тушаал	Овог нэр	Танилцсан эсэх	Гарын үсэг
1.					
2.					
3.					
4.					
5.					
6.					
7.					
8.					
9.					
10.					
11.					
12.					
13.					
14.					
15.					
16.					

**ЗААВАРЧИЛГАА ӨГСӨН:**

---

**4. Аварсан хүн /буцалтгүй нэрвэгдэгч/ -ийн тоо бүртгэл:**

№	Овог, нэр	Нас	Хүйс	Гэрийн хаяг	Шалтгаан	Тайлбар

**5.Ослын голомтод ажилласан байдал:**

